



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/678

Булган сум

Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх,
бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/473 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баталгаажсан үүлдэр, омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцын хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд: Ц.Бямбацогт (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Улсын байцаагч)

А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Д.Сэрчлхам (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: М.Жавзандолгор (Хүнс, хөдөө аж ахуйн газрын

Мал үржлийн албаны дарга)

3. Дээрх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт, ажлыг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Амгалан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ